



# УГСАРСАН НИЙЛМЭЛ ҮГ БҮТЭЭХ АРГА

**Дасгал даалгаврууд**

# Угсарсан нийлмэл үг бүтээсэн аргад тохирох жишээг зөв харгалзуулаарай.

| Угсарсан нийлмэл үг бүтээсэн арга                                                                                                             | Зөв хариулт | Жишээ үг                                |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----------------------------------------|
| 1. Өнгө зүс заасан тэмдэг нэрийг юм заасан жинхэнэ нэрд үндсээр нь холбон бүтээдэг.                                                           |             | а. Морин хийл, үхэр буу, тэмээн хяруул  |
| 2. Таван хошуу малын холбогдолтой жинхэнэ нэрийг амьтан, ургамал, зэвсэг хэрэглэл, бодис юмыг заасан жинхэнэ нэрд үндсээр нь холбож бүтээдэг. |             | б. Цагаан толгой, шар шувуу, цагаан сар |
| 3. Байгалийн төрөл бүрийн бодис юмсыг нөгөө бодис юмстай жишиж, өөр хооронд нь үндсээр нь холбож бүтээдэг.                                    |             | в. хөл машин, гар бөмбөг, гар чийдэн    |
| 4. Орон цаг, учир шалтгааны холбогдол бүхий хоёр жинхэнэ нэрийг үндсээр нь холбож бүтээдэг.                                                   |             | г. Усан болор, мөнгөн ус, хайлуур жонш  |
| 5. Орны холбогдолтой жинхэнэ нэрийг өнгө зүс заасан тэмдэг нэртэй үндсээр нь холбож бүтээдэг.                                                 |             | д. Магнай халзан, шийр алаг, бөөр алаг  |

## Угсарсан нийлмэл үг бүтээсэн аргад тохирох жишээг зөв харгалзуулаарай.

| Угсарсан нийлмэл үг бүтээсэн арга                                                                                                   | Зөв хариулт | Жишээ үг                                                                 |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|--------------------------------------------------------------------------|
| 6. Өнгө зүс заасан тэмдэг нэрийг өнгө зүсний дээд чанарыг агуулсан тэмдэг нэртэй үндсээр нь холбон бүтээдэг.                        |             | е. Бор ногоон, цагаан цэнхэр, улаан зээрд, хул хонгор                    |
| 7. Өнгө заасан тэмдэг нэрийг нөгөөд нь үндсээр нь холбож, завсрын өнгө зүс бүтээдэг.                                                |             | ё. Үнсэн саарал, гал улаан, элгэн хүрэн, хун цагаан,                     |
| 8. Үйл үгийг тодотгон холбох –х, сан-, даг (-дэг, дог, дөг) нөхцөлөөр нэр үгэнд захируулан холбож найрсан угсраа нэр үгийг бүтээнэ. |             | ж. туулайн бөөр, үхрийн нүд, хээрийн галуу, чонын элэг, ямаан ууц        |
| 9. Нэг нэр үгийг нөгөөтэй нь харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр холбож, найрсан угсраа нэр үгийг бүтээнэ.                           |             | з. дүрслэх урлаг, нисэх онгоц, лавлах товчоо, нисдэг тэрэг, хянах самбар |

# Дараах үгсээр угсарсан нийлмэл үг бүтээгээрэй. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж, өгүүлбэрийг гүйцээнэ үү.



1. Хаантан минь! Та энэ халуун газрыг явган туулж морилов уу?  
- Үгүй ээ, ..... -ээр ирлээ.  
- Тэгвэл хаантан минь, танаас асууж болох сон болов уу? ..... гэж морийг хэлээд байна уу?  
- Үгүй ээ, морь бол морь...
2. Жижиг буурцаг сагс бүхий гашуун амттай, сэнгэнэсэн үнэртэй нэг наст өвсийг ..... гэнэ.
3. .... бол нүүдэлч малчин айлын хоймроос төрийн хоймор хүртэл дуурсаж, улмаар Монголын нэрийн хуудас, бэлгэ тэмдэг, бидний омог бахархлын аялгуу болон цацран дуурсах хувь тавилантай байжээ.

**Толь бичиг ашиглан, утгыг тайлбарлаарай.**

Тэмээн харгана –

Үхэр харгана –

Ямаан харгана –



# Дараах гадаад үгсийн утгыг тохирох нийлмэл үг бүтээн илэрхийлээрэй.

канон -

принтер -

интернет -

мэйл -

такси -

реклам -

пакет -

паркет -

скоч -

заал -